



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/А82

Булган сум

Ерөнхий боловсролын сургуулиудад
сэтгэл зүйч ажиллуулах, "Сэтгэл зүйн" сургалт
зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/25 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Булганы Сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IX хуралдаанаас баталсан "Амжилтын гараа" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор, Аймгийн Засаг даргын 2025 оны "Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай" А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Амжилтын гараа" хөтөлбөрт заасан сургуулиудад сэтгэл зүйч ажиллуулах ажлыг зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалт, зөвлөгөөг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Боловсролын газрын дарга (Ц.Цолмонбаатар)-д үүрэг болгосугай.

3. Сургалтад зарцуулагдах 4,915,850 (дөрвөн сая есөн зуун арван таван мянга найман зуун тавь) төгрөг, шатахуунд зарцуулагдах 659,850 (зургаан зуун тавин есөн мянга найман зуун тавь) төгрөгийг "Амжилтын гараа" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 18 ны/ний өдрийн
А/182 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

**“АМЖИЛТЫН ГАРАА” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
ЗӨВЛӨХ БАГШ, СЭТГЭЛ ЗҮЙЧ НАРЫГ АЖИЛЛУУЛАХ УДИРДАМЖ**

1.Удирдамжийн зорилго:Булган аймгийн бага боловсролын чанарыг сайжруулах, сурагч бүрийн хөгжлийг дэмжих, сэтгэл зүйн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор “Амжилтын гараа” хөтөлбөрийн хэрэгжилтэд зөвлөх, тэргүүлэх багш, сургуулийн сэтгэл зүйч нарын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, ажлын чиг үүргийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах, хянах нэгдсэн удирдамжийг гаргах.

Хоёр.Зорилт:

1.Бага боловсролын чанарыг сайжруулах зорилгоор зөвлөх, тэргүүлэх багш нарын дэмжлэгт хандсан арга зүй, хичээл судлалын ажлыг тогтмолжуулах.

2.Сурагчийн хөгжлийг дэмжих, унших, бичих, тооцоолох чадварыг ахиулах чиглэлд зөвлөх багш нарын мэргэжлийн туслалцааг үр дүнтэй зохион байгуулах.

3.Сэтгэл зүйн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор сургуулийн сэтгэл зүйч нарын ур чадварыг дээшлүүлж, сурагч, багш, эцэг эхийн хамтын ажиллагаанд суурилсан зөвлөгөө, дэмжлэгийн үйл ажиллагааг өргөжүүлэх.

4.Багш–сурагч–эцэг эх–сургууль гэсэн дөрвөн талын хамтын оролцоог идэвхжүүлж, сургалтын болон сэтгэл зүйн ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх.

5.Сургалтын болон сэтгэл зүйн ажлын үр дүнг үнэлэх, хянах нэгдсэн тогтолцоо бүрдүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.

6.Сургуулийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, багш нарын мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх замаар аймгийн хэмжээнд бага боловсролын чанарын шинэ загварыг төлөвшүүлэх.

3.Хамрах хүрээ:Булган аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын бага боловсролын багш нар, сургуулийн удирдлага, сургалтын зөвлөх, тэргүүлэх багш нар, сэтгэл зүйч нар, аймгийн болон бүсийн боловсролын байгууллагууд хамрагдана.

Бүсчлэл:

Чин толгой, Дархан хан, Уран тогоо, Сэлэнгэ

4.Зохион байгуулагдах газар, хугацаа:

- Урд бүс: Бүрэгхангай, Дашинчилэн сум 2025 оны 12 дугаар сарын 15-18
- Хойд бүс: Хутаг-Өндөр, Хангал сум 2025 оны 12 дугаар сарын 22-26

5.Үндсэн чиглэл:

1.Зөвлөх, тэргүүлэх багшийн үүрэг, чиглэл:

- ✓ Сургалтын чанар, хичээлийн арга зүйн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, багш нарын ажлын байран дахь хөгжлийг дэмжих
- ✓ Сургалтын төлөвлөлт, хичээл судлал, үнэлгээний арга зүйг сайжруулах зөвлөгөө, сургалт зохион байгуулах;

- ✓ Сургалтын хэрэглэгдэхүүн, цахим контент боловсруулах, сайн туршлага түгээн дэлгэрүүлэх;
- ✓ Бага ангийн сурагчдын унших, бичих, тооцоолох чадварыг ахиулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх.

2. Сэтгэл зүйчийн үүрэг, чиглэл:

- ✓ Сурагчдын сэтгэл зүйн онцлог, хөгжлийн хэрэгцээнд суурилсан зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- ✓ Сургалтын стресс, урамшуулал, зан үйлийн асуудал дээр багш, эцэг эх, сурагчидтай хамтарч ажиллах;
- ✓ Сургуулийн хамт олны сэтгэл зүйн эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, анги хамт олны уур амьсгалын үнэлгээ хийх;
- ✓ “Амжилтын гараа” хөтөлбөрийн хүрээнд сэтгэл зүйн сургалт, зөвлөгөө, уулзалт, кейс судалгааны уулзалтыг зохион байгуулах.

3. Хамтын ажиллагаа, зохион байгуулалт:

- ✓ Зөвлөх багш, сэтгэл зүйч нар хамтран багш–сурагч–эцэг эх–сургууль гэсэн 4 талын оролцоог идэвхжүүлнэ;
- ✓ Сургуулийн удирдлага хөтөлбөрийн хүрээнд зөвлөх багш, сэтгэл зүйчийн жил бүрийн төлөвлөгөө, тайланг боловсруулж, аймгийн боловсролын газарт хүргүүлнэ;
- ✓ Бүсийн болон аймгийн хэмжээнд зөвлөгөөний уулзалт, кейс хэлэлцүүлэг, хяналт-шинжилгээний уулзалтыг зохион байгуулна.

6. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдах, хянах:

- ✓ Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Боловсролын газар удирдан зохион байгуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийнэ.
- ✓ Сургуулиуд зөвлөх багш, сэтгэл зүйчийн ажлын үр дүн, нөлөөллийн үнэлгээ хийж, тайланг аймгийн Нийгмийн Бодлогын хэлтэст ирүүлнэ.
- ✓ Хяналт-шинжилгээнд багш, сурагч, эцэг эхийн санал судалгааг тусган, үнэлгээг боловсронгуй болгоно.

7. Хүлээгдэж буй үр дүн:

- ✓ Бага ангийн сурагчдын суралцахуйн амжилт, сэтгэл зүйн дасан зохицол 70 хувь ба түүнээс дээш түвшинд хүрнэ;
- ✓ Багш, сэтгэл зүйч нарын хамтын зөвлөгөө, мэргэжлийн дэмжлэг тогтмолжино;
- ✓ Сургалтын болон сэтгэл зүйн орчин аюулгүй, хүртээмжтэй, хүүхэд бүрийн хөгжилд дэмжлэгтэй болно;
- ✓ Эцэг эх, олон нийтийн оролцоо нэмэгдэж, хамтын оролцоонд суурилсан боловсролын загвар төлөвшинө.

8. Хэрэгжүүлэх хугацаа: 2025-2028 онд 3 жилийн хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

